Эрүүл Мэндийн Газар Хяналт Шинжилгээ Үнэлгээ
Мэдээлэлийн Хэлтэсээс бэлтгэн гаргав

Мэдээ хянасан
ХШҮМ*Х-ийн дарга Д.Наранмичид*

Мэдээ нэгтгэсэн
Мэргэжилтэн *Т.Ууганжаргал*

Утас : 70562096
Вэб сайт:mohs.khe.gov.mn

Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх
Хэрэгжүүлэгч агентлаг
Эрүүл Мэндийн Газар

ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ
2023 ОНЫ 2 САР

Чингис хот

Эх, хүүхдийн эрүүл мэнд
/2023 оны 2 сарын байдлаар/

Төрөлт

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 2 сарын байдлаар нийт 204 эх төрсөн ба өнгөрсөн оны мөн үеэс 29 төрөлтөөр буюу 14.2 хувиар буурсан байна. Аймгийн нэгдсэн эмнэлэгт 72,0% /147/ нь сумдаас ирж төрсөн байна.
Кесар хагалгаагаар төрсөн /55/ 27,0 хувийг эзэлж байна

Хүүхдийн эрүүл мэнд

2023 оны 2 сард Аймгийн хэмжээнд 205 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 29 хүүхдээр буюу 14.1 хувиар буурсан байна. Нийт амьд төрсөн хүүхдийн 98 буюу 47.8 хувь нь эрэгтэй, 107 буюу 52.2 хувь нь эмэгтэй байна. Амьд төрсөн хүүхдийн 3.4/7/ хувь нь бага жинтэй буюу 2500 гр-аас доош жинтэй төржээ. Төрөөд 1 цагийн дотор хөхөө амласан хүүхдийн эзлэх хувь 97,1 байна.

Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

Аймгийн хэмжээнд 2023 оны 2 сард нялхасын эндэгдэл 4 тохиолдол бүртгэгдсэн ба 1000 амьд төрөлтөд 19,5 байна. Улсын дундаж 13,7
5 хүртэлх насны эндэгдэл 4 тохиолдол бүртгэгдсэн ба 1000 амьд төрөлтөд 19.5 байгаа нь өмнөх оны мөн үеэс 8.1 промилоор өссөн байна. Улсын дундаж 15,3 промил байна.

Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан

5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг шалтгаанаар нь авч үзвэл: Нярайн тархины эмгэг-1, нярайн төрөлхийн пневмони-1, уушигны хатгалгаа-1, тархины цус харвалт-1 тус тус бүртгэгдсэн байна.

Жирэмсний хяналт

Жирэмсэний хяналтанд шинээр 229 жирэмсэн эмэгтэйчүүд хамрагдсан ба 93,0 хувь нь эхний 3 сартайд, 6,2 хувь нь 4-6 сартайд, 7 дээш сартайд 0,8 хувь нь хяналтанд орсон байна. Хяналтанд орсон жирэмсэн эмэгтэйчүүдийн 95,6 хувь нь цусны шинжилгээнд хамрагдсан ба цус багадалттай жирэмсэн бүртгэгдээгүй байна.
Шинээр хяналтанд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдээс трихомониаз илрүүлэх шинжилгээнд 166 буюу 72,4 хувь нь эерэг-1, заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 166 буюу 72,4 хувь, тэмбүү илрүүлэх шинжилгээнд 227 буюу 99,1хувь, эерэг-1, ХДХВ/ДОХ илрүүлэх шинжилгээнд 227 буюу 99,1 хувь тус тус хамрагдсан байна.

Нас баралтын үзүүлэлтүүд

2023 оны эхний 2 сарын байдлаар нийт нас баралтын 66 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийн түвшинд байна. 42 буюу 63,6 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Нас баралтын түвшин 1000 хүн амд 2,0 байна.

Нийт нас баралтын 42,4 хувь нь эмнэлэгт нас барсан бөгөөд үүнээс 32,1 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж байна..

Хорт хавдрын шалтгаант нас баралт нийт нас баралтын /16/ 24,2 хувийг эзэлж байна.

Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 17 тохиолдол бүртгэгдэж, нийт нас баралтын 25,7 хувийг эзэлж байна. Амиа хорлосон-2, бусдад хорлогдсон 1 тохиолдол, зам тээврийн осол-6, бусад осол-8 тус тус бүртгэгдсэн байна. 10000 хүн амд ногдох осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 2,1 байна.

2023 оны эхний 2 сарын байдлаар артери гипертензийн эрт илрүүлэг үзлэгт нийт 4679 хүн хамрагдаж 60,5 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр онош батлагдсан 28 байна. Чихрийн шижингээр онош батлагдсан 6 тохиолдол байна.

Хөхний эрт илрүүлэг үзлэгт 1493 хүн хамрагдаж, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт 172 хүн хамрагдсан байна.

Амбулатори ,стационарын тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 2 сарын байдлаар эмнэлэгт 3544 хүн хэвтэн эмчлүүлж нийт 26950 ор хоног ашигласан бөгөөд дундаж ор хоног 7,6 байна.

Амбулаторит 2023 оны эхний 2 сарын байдлаар 54853 үзлэг хийгдсэний 14,3 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 68,3 хувийг өвчний учир амбулаторит, 9,9 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, үлдэх 7,5 хувийг гэрийн идэвхитэй болон дуудлагын үзлэг эзэлж байна.

Халдварт бус өвчлөл 22162 бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үеийнхээс 7366 өвчлөлөөр өссөн үзүүлэлттэй байна.

2023 оны 2 сарын байдлаар Осол гэмтлийн өвчлөлийн нийт 243 тохиолдол бүртгэгдсэнээс /151/62,1 эрэгтэй, /92/37,8 эмэгтэй байна. Осол гэмтлийн тэргүүлэх 5 шалтгаанд: бүх төрлийн уналт /93/38,2%, зам тээврийн осол /44/18,1%, амьгүй механик хүчин өртөх /39/16,0%, хүчирхийлэл /26/ 10,7% түлэгдэлт /19/ 7,8%, тус тус эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 2023 оны 2 сарын байдлаар 3971 түргэн тусламжийн дуудлага хүлээн авч гүйцэтгэснээс 17,6% нь алсын дуудлага эзэлж байгаа нь өмнөх оноос 3,0 хувиар буурсан байна. Осол гэмтлийн 88 дуудлага бүртгэгдсэн байна.

10000 хүн амд ногдох халдварт өвчин
2023 оны эхний 2 сарын байдлаар

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 2 сарын байдлаар 67 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 8,3 ногдож байна. /Улсын дундаж 12,9/ Улс аймгийн дундажаас доогуур үзүүлэлттэй байна.

Халдварт өвчин бүтэц



Нийт халдварт дотор Салхинцэцэг /41/ 61,1 хувь, БЗДХ /12/ 17,9 хувь, сүрьеэ /9/ 13,4 хувь, цусан суулга /2/2,9 хувь, ковид-1 1,5 хувь тус тус бүртгэгдсэн байна.

БЗДХ-ын 12 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 1,5 байна. БЗДХ-ын дотор т эмбүү /4/, гонококт халдвар /4/, трихомониз /4/, тохиолдол бүртгэгдэж урьд оноос 3 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.